



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн орон тооны жишиг батлах тухай” А/125 дугаар тушаалын хавсралтын “1.Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар” хэсэг, 2.”Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар” хэсгийг хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан орон тооны жишигт нийцүүлэн Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлахыг аймгийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3. Орон тооны жишиг, албан тушаалын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан байгууллагын нэгж, албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж баталж, хэрэгжүүлэхийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг үндэслэн төсөвт холбогдох зохицуулалтыг хийж, хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /О.Хуягцогт/-т даалгасугай.

5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн орон тооны жишиг батлах тухай” А/125 дугаар тушаалын хавсралтын “1.Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар”, 2.”Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар” хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14231 0271

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн
А/67 дүгээр тушаалын хавсралт



1. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

Албан тушаалын нэр, орон тооны жишиг		23-25
1	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	1
2	Сургалт, судалгаа, арга зүйн асуудал хариуцсан нэгжийн дарга (Сургалтын бодлого, хэрэгжилт, сургалт эрхлэх зөвшөөрөл, тэгш хамран сургалт, боловсролын баримт бичиг олгох асуудал)	1
3	Сургалтын арга зүй, багшийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч)	10-12
	• Сургуулийн өмнөх боловсрол	1-2
	• Бага боловсрол	1-2
	• Суурь бүрэн дунд боловсрол. Үүнд.	8
	- Монгол хэл, бичиг, уран зохиол - Математик, мэдээллийн технологи - Байгалийн ухаан (физик, биологи, хими, газар зүй) - Нийгмийн ухаан (түүх, нийгэм судлал, иргэний ёс зүйн боловсрол) - Дүрслэх урлаг, зураг зүй, технологи - Хөгжим - Биеийн тамир/эрүүл мэнд - Гадаад хэл	
	• Шинжлэх ухаан, технологи, инноваци, дээд боловсрол, мэргэжлийн боловсролын сургалт, багшийн хөгжил, орчин хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч)	1
4	Хүүхдийн хөгжил хамгаалал, сурах бичиг, сургалтын орчин, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч)	1
5	Статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч)	1
6	Цахим технологи, мэдээллийн сүлжээ хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч)	1
7	Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах арга зүйч	1
8	Хөрөнгө өрүүлэлт, төсвийн гүйцэтгэл хариуцсан ахлах арга зүйч	1
9	Боловсролын хяналтын улсын байцаагч	1
10	Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч (Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймагт)	1
11	Нягтлан бодогч	1
12	Нярав	1
13	Архив, бичиг хэргийн ажилтан	1

Тайлбар:

- Нутаг дэвсгэрийн хэмжээнд (аймаг, нийслэл, дүүрэг) сургуулийн өмнөх болон бага боловсролын багшийн тоо 200 ба түүнээс дээш бол тухайн чиг үүргийг 2 ахлах арга зүйч (арга зүйч) тус тус хариуцан ажиллана.
- Баян-Өлгий аймагт монгол хэл, бичгийн сургалт, монгол хэлний багшийн хөгжил хариуцсан нийт 2 ахлах арга зүйч (арга зүйч) ажиллана.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хуульд заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны газарт эзэмшүүлсэн байртай бол үйлчилгээний ажилтныг батлагдсан төсөвтөө багтаан ажиллуулж болно. Энэ тохиолдолд үйлчилгээний ажилтны тоо нийт орон тооны 15 хувиас илүүгүй байна.

2.Говьсүмбэр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

Албан тушаалын нэр, орон тооны жишиг		11
1	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	1
2	Сургалт, судалгаа, арга зүйн асуудал хариуцсан нэгжийн дарга (Сургалтын бодлого, хэрэгжилт, сургалт эрхлэх зөвшөөрөл, боловсролын баримт бичиг, шинжлэх ухаан, технологи, инноваци мэргэжлийн боловсролын асуудал)	1
3	Сургалтын арга зүй, багшийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч <ul style="list-style-type: none">• Сургуулийн өмнөх боловсрол• Бага боловсрол• Суурь бүрэн дунд боловсрол	3
4	Хүүхдийн хөгжил хамгаалал, тэгш хамран сургалт, сурах бичиг, сургалтын орчин, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч)	1
5	Статистик мэдээлэл, цахим технологи, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч)	1
6	Боловсролын хяналтын улсын байцаагч	1
7	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах арга зүйч	1
8	Нягтлан бодогч	1